



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖУУЛЭГЧ АГЕНТЛАГ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,

Ц.Жигжиджавын гудамж-7/1,

Хангardi ордон

Утас: 31-80-03, Факс: (976-11) 32-06-69

<http://www.baigal.ub.gov.mn>

2019.05.04 № 01/476

танай _____ -ны № _____ -т

**“ТҮМЭН ШУВУУТ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Ж.БОЛД ТАНАА**

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хэрэгжих “Агро Фийд тэжээлийн үйлдвэр” төслийн баримт бичигт “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам”-ын 3 дахь хэсгийг үндэслэн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлээ.

Уг үнэлгээнд тусгагдсан нөхцөл болзлуудыг хэрэгжүүлж ажиллана уу.

Хавсралт 4 хуудастай.



1150500962

**ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ХУУДАС**

2017 оны 05-р сарын 03-нд

Улаанбаатар хот

Төслийн дугаар: **2017/048**

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: “Түмэн Шувуут” ХХК, Сонгинохайрхан дүүргийн 27-р хороо, 21-р хороолол, #52.

Төслийн нэр: “АгроЦ Файд малын тэжээлийн үйлдвэр” төсөл

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил: Сонгинхайрхан дүүргийн 21-р хорооны нутагт хэрэгжинэ.

Холбоо барих утас: **70005115.**

Орон нутгийн санал: Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газрын 2017 оны 04-р сарын 25-ны өдрийн 01/1060 тоот бичиг.

	Ерөнхий үнэлгээний гол шалгуурууд	Нийцсэн	Нийцээгүй	Нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай	Үндэслэл тайлбар
Төрийн бодлого, шийдвэрийн нийцэл	Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий телевлегөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагад	Тийм		Шаардлагагүй	
Төслийн байршил, түүнтэй холбогдох шалгуурууд	Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх (урсац бүрэлдэх эх, ойн болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, хилийн хамгаалалтын бүс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар г.м.)	Тийм		Шаардлагагүй	
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь хүний нелөө, байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг, мэдрэмтгий эсэх	Тийм		Шаардлагагүй	
	Болзошгүй хуримтлагдах нелөөлөл үүсгэх эсэх				Хуримтлагдах нелөөлөл үүсгэхгүй
Төслийн байгаль орчны нелөөллийн урьдчилсан	Агаарын чанар				
	Бохирдуулагч болон аюултай, хортой бодис	Тийм			Сөрөг нелөөлөл

үнэлгээ	агаар мандалд ялгаруулах, эсэх				бага зэрэг үүсгэнэ.
	Дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нэлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсэх, эсэх		Үгүй		Сөрөг нэлөөлөл үүсэхгүй.
	Усан орчин				
	Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомстол үүсэх, эсэх		Үгүй		Үүсэхгүй
	Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх		Үгүй		Үүсэхгүй
	Гадаргын болон газрын доорх усанд бохирдол үүсэх, эсэх		Үгүй		Үүсгэхгүй
	Хөрсөн бүрхэвч				
	Хөрсөн бүрхэвч эвдрэх, эсэх	Тийм			Хөрсөн бүрхэвчид дунд зэрэг нэлөөлнэ.
	Хөрс бохирдуулах эсэх	Тийм			
	Хөрс доройтох, цөлжих эсэх		Үгүй		
Ургамлан нэмрөг					
Нийгмийн нэлөөллийн урьдчилсан үнэлгээ	Ургамлан нэмрөг, ой мод өртөх эсэх		Үгүй		Ургамлан нэмрөг өртөхгүй.
	Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйлс өртөх, эсэх		Үгүй		Суурьшлын бүсэд байрлалтай ховор, нэн ховор ургамал байхгүй тул нэлөөлөхгүй
	Амьтны аймаг				
	Зэрлэг амьтдын амьдрах орчинг доройтуулах, эсэх		Үгүй		Суурьшлын бүсэд байрлалтай ховор, нэн ховор амьтан байхгүй тул амьдрах орчинд доройтуулахгүй
	Ховор, нэн ховор амьтан өртөх, эсэх		Үгүй		
	Нутгийн оршин суугчид				
	Газар эзэмших, ашиглах эрх зөрчигдэх, эсэх		Үгүй		Суурьшлын бүсэд байрлалтай нэлөөлөлд өртөхгүй.
	Нутгийн оршин суугчдын нийгмийн байдалд серег нэлөөлтэй, эсэх		Үгүй		
	Нэлөөлөлд өртөж болзошгүй төв, суурин газар байгаа, эсэх		Үгүй		
	Нүүлгэн шилжүүлэх		Үгүй		Суурьшлын бүсэд байрлалтай нэлөөлөлд өртөхгүй

	асуудал үүсэх, эсэх					
Түүх, соёлын биет өв						
	Серег нөлөөлөлд өртөх түүх, соёлын үнэт зүйлс бий эсэх		Үгүй		Суурьшлын бүсэд байрлалтай түүх, соёлын үнэт зүйлс байхгүй тул нөлөөлөлд өртөхгүй	
Хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл						
	Нутгийн иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм			Суурьшлын бүсэд байрлалтай нөлөөлөлд бага зэрэг өртне.	
	Төслийн бүх үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд эрсдэл үүсэх эсэх	Тийм				
Нэгдсэн дүгнэлт:						
<p>Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 21-р хороонд “Түмэн Шувуут” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Агро Фийд малын тэжээлийн үйлдвэр” төсөлд ерөнхий үнэлгээ хийснээр уг төслийг нөхцөл болзолтойгоор хэрэгжүүлэх боломжтой бөгөөд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл” дунд” зэрэг гэж үзлээ.</p>						
Онцгойлон анхаарах зүйлс:						
1.	Төслийн үйл ажиллагаа болон ахуйн хэрэглээнээс гарах хатуу, шингэн /аюултай/ хог хаягдлын хэмжээ, эх үүсвэрийг тодорхойлж, байгаль орчин, хүний эрүүл мэндэд халгүй аргаар цуглуулах, хуримтлуулах, ангилан ялгах, зайлуулах, боловсруулах зөвлөмж, технологийн дарааллыг тодорхойлж, графикт хугацаанд нэгдсэн хог хаягдлын цэгт зайлуулж байхаар харьяа дүүргийн ТҮК-тэй гэрээ байгуулан ажиллах;					
2.	Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах;					
3.	Орчны талбайг засаж тохижуулах зам талбайг тэгшлэх, эзэмшил газарт мод, бут, сөөг, зүлэг тарьж ургуулах арга хэмжээ авах дүйцүүлэн хамгаалалт хийх, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардлагах хөрөнгө зардлыг төсөвтөө суулгах;					
4.	Үйл ажиллагааны талаар мэргэжлийн байгууллагаас өгсөн заавар зөвлөмжийг бүрэн дагаж мөрдөх, “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны орчин эрүүл ахуйн шаардлага” MNS 4990:2000, стандартыг чанд баримтлан ажиллах;					
5.	Бохир усны цооног байгуулах, ашиглахдаа Байгаль орчин, Эрүүл мэндийн сайдын 1995 оны 169/171-р тушаалаар баталсан “Ахуйн бохир усны цооногийг доторлож ашиглах журам”-ыг мөрдлөг болгох;					
6.	Төслийн явцад хүрээлэн байгаа орчин, оршин суугчдад сөрөг нөлөөлөл үүсгэхгүй байх, үүсэх тоос, дуу чимээний бохирдлыг багасгаж, иргэдийн эрүүл амьдрах орчинд нөлөөлөхгүй байх;					
7.	Хөрс, ус, агаараас дээж авах цэгийг холбогдох стандартын дагуу тогтоож, шинжилгээнд дээж авах зөвлөмжийг тусгах, үнэлгээний шатанд хөрсний тодорхой гүнээс дээж авч шинжилгээнд хамруулан дүнг тайланд хавсаргах;					
8.	Төслийн явцад тахианы бүрэн найрлагат багсармал тэжээл техникийн ерөнхий шаардлага MNS 5929:2008 стандартыг чанд мөрдөн ажиллах;					
9.	Тахианы бүрэн найрлагат багсармал тэжээлийг хадгалахдаа хүнсний бүтээгдэхүүний					

ПДВЭРН
ВУУТ
1901
753
АТАР ХС

агуулахын MNS 5364:2004, тээвэрлэхдээ MNS 5647:2005, тэжээлийг хаяглахдаа MNS 4579:98 стандартуудыг мөрдөн ажиллах;

10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг /Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр/ боловсруулж жил бүрийн 2 улиралд багтаан тус газраар батлуулах, тайланг жилийн эцэст дүгнүүлж ажиллах;
11. Дээрх нөхцөл болзлын бие лэлтийг тайлгаж ажиллаагүй бол Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 25-30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;
12. Төслийн явцад ариутгал халдвартайжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар зориулалтын техникээр хийлгэх;

Ерөнхий үнэлгээ хийсэн:

Овог, нэр: С. Долгормаа
Алба тушаал: Нийслэлийн Байгаль орчны
газрын мэргэжилтэн
Гарын үсэг:
Огноо: 2017.05.03

Ерөнхий үнэлгээний үр дүнг зөвшөөрсөн:

Овог, нэр: Ж. Болд
Алба тушаал: Гүйцэтгэх захирал
Гарын үсэг:
Огноо: 2017.05.03

СЧ
СЖ